

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 01 дүгээр сарын 25


Замын-Үүд сум

Тус газар нь МУ-ын Хилийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2010 онд баталсан 338,339,340 журам, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2017 оны 12 сарын 11-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар

Тайлант хугацаанд 4 орны 20 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон байна. Үүнд, нэг удаагийн орох 3 иргэн, нэг удаагийн гарах-орох 6 иргэн, визийн шилжүүлэг 8 иргэн, дамжин өнгөрөх 3 иргэн, түр ирэгчийн бүртгэл 31, хасалт 35, оршин суух зөвшөөрлийн хасалт 77 хийсэн.



1.2. Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар

Боомт, орон нутгийн хэлтсийн даргын 2017.05.26-ны өдрийн 11/2092 тоотийг үндэслэн хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 3565 иргэн /давхардсан тоогоор/-ний хөдөлгөөнд, бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд болон Төвөөс алдаатай олгогдсон БНХАУ-ын 6 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1.4. БНХАУ-ын нэг өдрийн бүлэг жуулчдын талаар

Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хотод суух консулын газраас олгосон нэг өдрийн БНХАУ-ын 14 жуулчдын хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан.

1.3. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6, Засгийн Газрын 2010 оны 338 дугаар тогтоолын 4.1, болон Монгол улсад орох визгүй нийт 1 орны 17 иргэнийг улсын хилээр оруулалгүй буцаан ажилласан.

1.4. Захиргааны арга хэмжээ авсан талаар

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 1 орны 19 гадаадын иргэнийг 2760000 төгрөг, үүнээс 3 аж ахуйн нэгж байгууллагын 10 иргэнд 1560000 төгрөг, уригч 1 иргэний урьсан 1 гадаадын иргэнд 250000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

1.5. Хяналт шалгалтын талаар

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэв баг Алаг толгойд байрлах “Чингисийн хар алт” ХХК-ны охин компани болох “Ачир” ХХК-аас Виз, зөвшөөрлийн газарт БНХАУ-ын 14 иргэний Монгол Улсад байх визийн хугацааг сунгуулах талаар гаргасан хүсэлтийг хүлээн авч хяналт шалгалтаар нарийвчлан судлуулахаар шилжүүлсэн байх тул Дорноговь аймаг дахь газрын даргын 2018 оны 01дүгээр сарын 17-ны өдрийн ДГ-2018/01 тоот хяналт шалгалтын удирдамжын дагуу Хяналтын улсын байцаагч Д.Одхүү, Мэргэжилтэн Т.Даваадаш,жолооч Я.Гончигсүрэннар 2018 оны 01дугаар сарын 18-ны өдрөөс 19-ны өдрийн хооронд тухайн байгууллагад байх гадаадын иргэд нь Монгол Улсад ирсэн зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг нягтлан шалгахаар төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд “Ачир” ХХК-ны нүүрс угаах, боловсруулах үйлдвэрт зөвлөгөө өгч буй БНХАУ-ын 15 иргэн хамрагдав. Уг БНХАУ-ын 15 иргэн нь тус үйлдвэрийн ашиглах технологийн горим, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, автоматжуулалт, цахилгаан хангамж, дулааны хангамж зэрэг ажлуудад Монголын 35 ажилтанг сургаж, дадлагажуулаж, зөвлөгөө өгч байсныг тогтоосон.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгах санал, албан хаагчдын ажилласан жилийн судалгаа зэргийг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүлэв.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Дорноговь аймаг дахь газар нь албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг мөрдөж ажилладаг “Хяналтын карт”, ирсэн бичиг, өргөдөл, гомдолд “Бүртгэл хяналтын карт”-ыг тухай бүр хөтөлдөг ба хариутай албан бичгийг стандартын дагуу боловсруулдаг болно.

Тайлант хугцаанд тус газрын бичиг хэрэгт 23 албан бичиг ирснийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 11 албан бичиг 3 өргөдлийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажилласан ба 25 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Харин тус газарт ирсэн гомдол байхгүй болно.

2.4. Хүний нөөц, сургалтын талаар

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсонтой холбогдуулан ГИХГ-ын даргын энэ оны Б/51 дүгээр тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд бүртгэлтэй байгаа 24 албан хаагчаас 22 албан хаагч ажиллаж байна. Үүнээс сургуулийн чөлөөтэй 1, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байна.

Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулиар сургалт зохион явуулж сургалтанд 17 албан хаагч хамрагдсан.



2.5. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар

Тайлант хугацаанд батлагдсан төсөв болох 61,194 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, зарлагын 78,652.0 мянган төгрөгний гүйлгээг Замын-Үүд төрийн сангаар хянуулан хийлгэж данс бүртгэлд бүртгэсэн. 2017 оны 12 дугаар сар болон 2018 оны 01 дүгээр сарын албан хаагчдын цалинг бодож олгосон.


Жилийн эцсийн тооллогыг 2017 оны 12 сарын 22-25-ны өдрийн хооронд хийж илтгэх хуудсаар газрын даргад танилцуулсан. 2017 оны шилжүүлэн авсан болон шилжүүлсэн үндсэн хөрөнгө бараа материалын орлого зарлагыг ерөнхий газрын тооцооны нягтлан бодогчтой тооцоо нийлсэн. 2017 оны Татварын тайланг ИХШХЕГ-ын Дорноговь аймаг дахь газар /РД:2712253/ болон ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газар /РД:3315398/ регистрийн дугаарт цахим сайтад шивж тоон гарын үсгээр баталгаажуулсан.

Говьсүмбэр аймаг дахь албаны мэргэжилтэний өрөөг засварлан тохижуулан ажилласан.

өмнө



дараа



2.6. Мэдээллийн технологийн чиглэлээр

Тайлант хугацаанд газрын хэмжээнд мэдээллийн технологийн ажлын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, эрхэлсэн ажлын хүрээнд удирдлагыг мэдээллээр ханган, нийт 23 удаагийн дуудлага хүлээн авч албан хаагчдын компьютер, техник хэрэгсэлд шаардлагатай үйлчилгээг хийсэн.

Гурав. Бусад

Албан хаагчдын хурлыг 2 удаа зохион байгуулж, тус газрын хийж гүйцэтгэсэн ажлын талаар тайланг тавьж албан хаагчдын санал хүсэлтийг сонсож шийдвэрлэн ажилласан.

Тус газар нь 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдөр шинэ жилийн баярын үйл ажиллагаагаа зохион явуулсан. 2017 онд ажилдаа идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй хөдөлмөрлөж, хамт олноо манлайлан ажилласан оны шилдэг ажилтангаар мэргэжилтэн Д.Баасансүрэн, жолооч Я. Гончигсүрэн, Замын-Үүд сумын Засаг даргын Өргөмжлөл-р сантеникч М.Лутбаяр, Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Д. Одхүү, Жууч бичиг-р ахлах нягтлан бодогч Б. Болормаа, Хяналтын улсын байцаагч О. Хэрлэн тус тус шагнуулсан болно.

Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтын зөвлөлийн хурал энэ оны 01 дүгээр сарын 10-ны өдөр болж хурлаар Замын-Үүд Олон Улсын хилийн боомтод 2017 онд хийсэн ажлын талаар байгууллагын дарга, удирдах албан тушаалтан нар товч мэдээлэл хийж, 2018 онд боомтод мөрдөх журамд оруулах санлаа солилцон баталсан.